

“НИЙСЛЭЛ УЛААНБААТАР ХОТЫН  
АВТО ЗАМЫН ТҮГЖРЭЛИЙГ  
БУУРУУЛАХ НЭГДСЭН ТӨСӨЛ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ” УТҮГ-ЫН  
ЗАХИРАЛ

НИЙСЛЭЛ  
УЛААНБААТАР ХОТЫН  
АВТО ЗАМЫН  
ТҮГЖРЭЛИЙГ БУУРУУЛАХ  
НЭГДСЭН ТӨСӨЛ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖ  
УТҮГ

У.БААТАР

НИЙСЛЭЛ УЛААНБААТАХ ХОТОД ИХ БАГТААМЖИЙН НИЙТИЙН ТЭЭВРИЙН  
ХЭРЭГСЭЛ “МЕТРО”-Г БАРИХ ТӨСЛИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТЕХНИКИЙН  
ТОДОРХОЙЛОЛТ, ОЛОН УЛСЫН НЭЭЛТТЭЙ ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН  
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХАД ХУУЛЬ ЗҮЙН  
ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024.05.10

№ ЗҮД2024/001

Улаанбаатар хот

**Нэг. Үндэслэл**

- 1.1. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 411 дүгээр тогтоол, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 25 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/387 дугаар захирамж.

**Хоёр. Зорилго**

- 2.1. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний техникийн тодорхойлолтыг боловсруулах, төсөл хэрэгжүүлэх компанийг сонгон шалгаруулах ажилд хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- 2.2. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн болон тус төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээний олон улсад нээлттэй тендер шалгаруулалттай холбоотой тендер шалгаруулалтын материал, гэрээний төслийг олон улсын жишигт нийцүүлэн бэлтгэх;
- 2.3. Олон улсын жишиг гэрээний сургалтыг Захиалагч талын ажилтнуудад зохион байгуулах;
- 2.4. Энэхүү ажлын даалгаврын 2.1, 2.2-т заасан зорилгыг хэрэгжүүлэхэд дотоод болон шаардлагатай тохиолдолд гадаадын олон улсын туршлагатай мэргэжлийн баг ажиллуулж зөвлөмж, дүгнэлт, тайлан гаргуулах.

**Гурав. Хүрэх үр дүн**

- 3.1. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний техникийн тодорхойлолтыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулахаас гадна Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн

хэрэгсэл “Метро” барьж байгуулах төсөл болон тус төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээний олон улсын нээлттэй тендер шалгаруулалтын тендерийн баримт бичиг, түүний бүрдэл болох гэрээг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, хууль зүйн зөвлөгөө өгөх ажлыг хийж гүйцэтгэх.

#### **Дөрөв. Зөвлөх үйлчилгээний хамрах хүрээ**

Зөвлөх үйлчилгээний баг нь Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төсөл болон төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээнд хууль зүйн болон бусад чиглэлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг дараах хүрээнд хийж гүйцэтгэнэ:

1. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээний Техникийн тодорхойлолт боловсруулахад оролцох, хянах, санал боловсруулах;
2. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төсөл болон төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээний Тендер шалгаруулалтын баримт бичиг, гэрээний нөхцөлийг тодорхойлж, гэрээний төслийг бэлтгэх;
3. Олон улсын FIDIC холбооноос гаргасан жишиг гэрээний сургалтыг Захиалагч талын ажилтнуудад зохион байгуулах.

#### **4.1. Төслийн техникийн тодорхойлолт боловсруулахад оролцох, хянах, санал боловсруулах:**

- 4.1.1. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээний техникийн тодорхойлолтыг боловсруулахад оролцох, хянах, санал боловсруулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;
- 4.1.2. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээний техникийн тодорхойлолтод оролцогчдод тавигдах шаардлага боловсруулахад оролцох;
- 4.1.3. Төслийн зардлын тооцооллыг ажлын цар хүрээтэй уяж, гэрээний гүйцэтгэлийг оновчтой зохион байгуулах төслийг бэлтгэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх.

#### **4.2. Тендер шалгаруулалтын баримт бичиг, гэрээний нөхцөлийг тодорхойлж, гэрээний төслийг бэлтгэх.**

- 4.2.1. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төсөл болон төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээнд тохирох тендерийн жишиг баримт бичиг болон олон улсын гэрээний нөхцөлийг тодорхойлон Захиалагчид санал хүргүүлэх;
- 4.2.2. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл

“Метро” барьж байгуулах төсөл болон төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээний тендерийн жишиг баримт бичиг боловсруулахад зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

- 4.2.3. Нийслэл Улаанбаатар хотод их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгсэл “Метро” барьж байгуулах төсөл болон төслийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажил үйлчилгээний оролцогчдод тавигдах хууль зүйн шаардлагыг олон улсын жишигт нийцүүлэн Захиалагчид санал болгох;
- 4.2.4. Олон улсын зөвлөх инженерүүдийн холбооноос (FIDIC) эрхлэн гаргадаг ажил үйлчилгээний болон зөвлөх үйлчилгээний гэрээний нөхцөлийг санал болгох, төслийг англи, монгол хэл дээр бэлтгэх;
- 4.2.5. Олон улсын зөвлөх инженерүүдийн холбооноос (FIDIC) эрхлэн гаргадаг зөвлөх үйлчилгээний гэрээний нөхцөлийг лицензтэйгээр худалдан авч, төслийг бэлтгэх;
- 4.2.6. Тендер шалгаруулалтын явцад оролцогчдоос ирүүлсэн тодруулгад хариуг бэлтгэх;
- 4.2.7. Тендер шалгаруулалтын явцад оролцогчидтой хийх уулзалтад оролцож, тодруулгад хариуг бэлтгэх;
- 4.2.8. Санал болгосон олон улсын зөвлөх инженерүүдийн холбооноос (FIDIC) эрхлэн гаргадаг зөвлөх үйлчилгээний гэрээний орчуулгыг Захиалагчид хүргүүлэх.

### **4.3. Олон улсын жишиг гэрээний сургалтыг Захиалагч талын ажилтнуудад зохион байгуулах**

- 4.3.1. Олон улсын зөвлөх инженерүүдийн холбооноос (FIDIC) эрхлэн гаргадаг зөвлөх үйлчилгээний гэрээний сургалтыг Захиалагчаас санал болгосон 20 ажилтанд зохион байгуулах.

### **4.4. Зөвлөхөөс Захиалагчид ирүүлэх тайлан**

- 4.4.1. Зөвлөх нь хийж гүйцэтгэсэн ажлынхаа дундын болон эцсийн тайланг Захиалагчид ирүүлнэ.


#### **Зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай хүний нөөц**

Албан тушаал	Тавигдах шаардлага	Хүний тоо	Хүн/сар
Багийн ахлагч	1) Хууль зүйн магистр болон түүнээс дээш зэрэгтэй (гадаад улсад хамгаалсан байх) 2) Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх 3) Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хэрэгжүүлсэн эрчим хүч, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын 3-аас доошгүй төслийн хэлэлцээрт оролцсон, ФИДИК (FIDIC) гэрээний төсөл боловсруулсан байх	1	12 сар
Хуульч	1) Хууль зүйн магистр болон түүнээс дээш зэрэгтэй (гадаад улсад хамгаалсан байх) 2) Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх	1	12 сар

	3) Төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн хэрэгжүүлсэн эрчим хүч, дэд бүтэц, хөрөнгө оруулалтын төслийн хэлэлцээрт оролцсон, ФИДИК (FIDIC) гэрээний төсөл боловсруулсан байх		
Хууль зүйн мэргэжилтэн	1) Хууль зүйн бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй 2) Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх 3) Хөрөнгө оруулалт, IPO, өрийн хэрэгсэл гаргах чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх	1	12 сар


**Танилцсан:**

“Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгж” УТҮГ-ын Захиргаа, хүний нөөцийн албаны дарга

 /Б.Батдорж/

**Боловсруулсан:**

Гэрээ, эрх зүйн мэргэжилтэн

 /М.Уранбилэг/